

**Орон нутгийн хөгжлийн сангийн
зарцуулалт**

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
2017 ОН**

АГУУЛГА

Агуулга	2
Товчилсон үгийн жагсаалт	3
Аудитын нэр.....	4
Аудитын код.....	4
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	4
Аудитын зорилт	4
Аудитын хамрах хүрээ.....	4
Үндсэн мэдээлэл.....	4-5
Эрсдлийн үнэлгээ.....	5
Аудитын арга зүй.....	5
Шалгуур үзүүлэлтүүд.....	5
Аудит хийх багийн бүрэлдэхүүн.....	5-6
Аудит хийх хугацаа.....	6
Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц.....	6
Хавсралт №1 Эрсдлийн үнэлгээ.....	7
Хавсралт № 2 Асуудлын шинжилгээ	8
Хавсралт №3 Аудитын арга зүй	9-10
Хавсралт №4 Аудитын үр өгөөжийн төлөвлөлт	11
Хавсралт №5 Аудитын хөтөлбөр.....	12-13
Хавсралт №6 Судалгааны маягтууд /5 хүснэгтээр/.....	14-18
Хавсралт №7 Санал асуулгын маягт	19-20

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЭЗТХ	Эдийн засаг төлөвлөлтийн хэлтэс

БАТЛАВ. МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ХҮРЭЛБААТАР

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Аудитын нэр:

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт

2. Аудитын код:

ҮАГ-НАГ/2017/01-НА

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, ҮАГ-ын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

4. Аудитын зорилт:

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2016 оны төлөвлөлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэхэд аудит хийж, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг УИХ-д танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараахь дэд зорилтын хүрээнд аудит хийнэ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хууль журамд заасны дагуу төлөвлөж, гүйцэтгэсэн эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнасан эсэх.

5. Аудитын хамрах хүрээ:

Аудитад ОНХНС, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, ЗДТГ, СТСХ, ЭЗТХ, Баг, хороодын Засаг дарга, ИНХ-ыг хамруулж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2016 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагнал зэргийг авч үзнэ.

6. Үндсэн мэдээлэл:

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолд “Орон нутгийн хөгжлийн сан гэж орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон орлогын шилжүүлэг болон аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч Төсвийн тухай хуульд заасны дагуу бүрдүүлж, хуваарилан зарцуулах хөрөнгийг хэлнэ” гэж заасан байна.

2016 оны “Төсвийн тухай” хуульд ОНХНС-аас ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 131.0 тэрбум төгрөгөөр баталсныг Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн хуулиар 120.3 тэрбум төгрөг болгон өөрчилсөн байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас ОНХС-д олгох шилжүүлгийг тооцохдоо Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан *“Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”*-ыг мөрдөж байна.

Орон нутгийн удирдлага улсын төсвөөс орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хуваарилагдсан хөрөнгийг төлөвлөх, батлах, хуваарилах, нутгийн захиргаа, иргэд, олон нийтийн оролцоотой хамтын шийдвэрээр ил тод хариуцлагатай захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан *“Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”*, 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан *“Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”*-ыг баримтлан хэрэгжүүлж байна.

7. Эрсдлийн үнэлгээ:

Төлөвлөлтийн үе шатны ажлын явцад цуглуулж судалсан баримт, материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2016 оны зарцуулалтад хийх аудитын эрсдлийн ерөнхий үнэлгээг “Дунд” гэж үнэлсэн. /Дэлгэрэнгүйг Хавсралт №1-д үзүүлэв/

8. Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУС 100, 400, 4100, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан шалгагдагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, санал асуулга авах, харьцуулах, дүн шинжилгээ хийх, түүвэрлэлт хийх болон аудитын бусад горим, арга зүйг ашиглана.

9. Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудитын зорилттой холбоотой дараахь хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглана. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан *“Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”*;
- Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан *“Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”*
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам.

10. Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

• Аудитын явцыг хянан удирдах ажилтан: Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Алтанзул хянаж удирдаж, аудитын менежер Х.Болдбаатар аудитын стандарт, арга зүйн дагуу хяналт тавьж ажиллана.

• Аудит хийх аудитор, шинжээчид: Нийцлийн аудитын газрын ахлах аудитор Л.Хонгорзул, шинжээч М.Туул, А.Ариунзаяа, О.Ойгонбаяр болон аймаг, Нийслэлийн аудитын газруудын аудитор, шинжээч нар гүйцэтгэнэ.

11. Аудитын хугацаа:

Аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 9-нд эхэлж, 5 дугаар сарын 1-ний дотор Орон нутгийн аудитын газруудаас тайланг хүлээн авч, нэгдсэн тайланг бэлтгэж, Аудитын зөвлөлөөр хэлэлцүүлэн, Чанарын баталгаажуулалтын албаар хянуулан, МУЕА-ын тушаалаар баталгаажуулж, 2017 оны 6 дугаар сарын 20-ны дотор УИХ-д хүргүүлнэ.

Орон нутгийн Аудитын газрууд тайлангаа 2017 оны 5 дугаар сарын 1-ний дотор ҮАГ-ын Нийцлийн аудитын газарт файлаар (Ariunzaya@audit.gov.mn) хаягаар болон цаасаар ирүүлнэ.

12. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл:

Аудитын тайлангийн нэгдүгээр бүлэгт Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийн төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт, хоёрдугаар бүлэгт сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, гуравдугаар бүлэгт зарцуулалтад тавих хяналт, тайлагналын талаар тусгана.

13. Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц:

А. Боловсон хүчин:

- ҮАГ-аас 4 хүн: 90 өдөр, нийт 360 хүн/өдөр
- Орон нутгаас: 44 хүн 65 өдөр, нийт 2860 хүн/өдөр

Б. Санхүүгийн нөөц:

- цалин 303,517.2 мянган төгрөг
- томилолтын зардал: 10,000.0 мянган төгрөг

В. Техник хэрэгсэл: Зөөврийн компьютер, диктафон, скайнер, фото аппарат болон бусад техник хэрэгсэл.

Аудитын төлөвлөгөөг

Танилцсан:

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ДЭД ДАРГА

Б.БАТТУЯА

Хянасан:

НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.АЛТАНЗУЛ

Боловсруулсан:

АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
ШИНЖЭЭЧ

Х.БОЛДБААТАР
Л.ХОНГОРЗУЛ
М.ТУУЛ
А.АРИУНЗАЯА
О.ОЙГОНБАЯР

Ариунзаяа
Ойгонбаяр